



ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 5/10

Чингис хот

Зардал олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 1997 оны 19 дүгээр тогтоол, 1999 оны 39 дүгээр тогтоолуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын Засгийн Газрын тэтгэлгээр Удирдлагын академийн Төрийн алба, удирдлагын сургуулийн Төрийн захиргааны менежерийн зэрэг олгох 2017-2018 оны хичээлийн жилийн сургалтад хамрагдсан аймгийн Засаг даргын орлогч Г.Хэрлэнчулуун, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Л.Бат-Октябрь нарын Улаанбаатар хот ирж буцах болон суралцах хугацааны зам хоногийн зардалд тус бүр 175000 төгрөгийг олгосугай.

2. Дээрх зардлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын томилолтын зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч Н.Шинэбаярт зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

Аймгийн Засаг даргын Тамгын газрын
даргын 2018 оны 01 дугаар сарын 31
өдрийн 4/10 дугаар тушаалын хавсралт



Зардлын тооцоо

д/д	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэгж зардлын хэмжээ	Нийт олгох зардал
1.	Унааны зардал	Өндөрхаан-улаанбаатар	20000*2	40000
2.	Унааны зардал	Улаанбаатар-Өндөрхаан	20000*2	40000
3.	Зам хоногийн зардал	45 хоног	3000*2	270000
	Нийт дүн			350000